



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 18 өдөр

Дугаар А/529

Ховд

Хөрөнгө гаргах тухай


Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Тарваган тахал өвчний үеийн хариу арга хэмжээ” чиглэлээр дадлага сургуулилтыг зохион байгуулсан зардалд 432 000 төгрөг, Ахмад дайчинд хүндэтгэл үзүүлэхэд 85 500 төгрөг, Элсэлтийн ерөнхий шалгалтанд 800 оноо авсан элсэгчдэд өргөмжлөл хийлгэсэн зардалд 462 000 төгрөг, Зохиолч Ш.Тамирын номны үнэнд 1 100 000 төгрөг, Бүсийн хамтын ажиллагааны чиглэлээр Говь -Алтай аймгийн Засаг дарга, удирдлагуудтай хийсэн уулзалтын арга хэмжээний зардалд 490 000 төгрөгийг тус тус зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнүүдэд зарцуулах 2 569 500 төгрөг /Хоёр сая таван зуун жаран есөн мянга таван зуун/-ийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн ангилагдаагүй зардлын нөөцөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ